# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 10 сарын 17 өдөр　　　Дугаар 14　　　Улаанбаатар хот

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.9 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт нарын 11 гишүүнээс 2018 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

**Ажлын хэсгийн ахлагч:**

Ц.Гарамжав　　-Улсын Их Хурлын гишүүн

**Гишүүд:**

Ж.Батзандан　　-Улсын Их Хурлын гишүүн
О.Батнасан　　-Улсын Их Хурлын гишүүн
Л.Болд　　-Улсын Их Хурлын гишүүн
Х.Нямбаатар　　-Улсын Их Хурлын гишүүн
Ц.Мөнх-Оргил　　-Улсын Их Хурлын гишүүн
Л.Энхболд　　-Улсын Их Хурлын гишүүн

**Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:**

М.Үнэнбат　　-Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх ажлын дэд хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

В.Оюумаа　　-Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн

П.Сайнзориг　　-Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга

Б.Бат-Орших　　-Улсын ерөнхий прокурорын газрын Гэмт хэрэг, зөрчлийн бүртгэл, дүн шинжилгээний төвийн дарга

| | |
|---|---|
| Б.Батзориг | -Санхүүгийн зохицуулах хорооны Захиргаа, удирдлагын газрын дарга |
| З.Баасанням | -Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга |
| Т.Баярхүү | -Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга |
| Л.Нямгэрэл | -Хууль зүй, дотоод хэргийн яамны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга |
| Л.Нямдаваа | -Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга |
| Г.Арсланхуяг | -Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга |
| Ж.Амгалан | -Цагдаагийн ерөнхий газрын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны дарга |
| Х.Сүрэнхорол | -Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн |
| Б.Энхболд | -Хууль сахиулахын их сургуулийн Цагдаагийн сургуулийн эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн эрхлэгч |
| Б.Мөнхдорж | -Хууль сахиулахын их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан |
| Ц.Цэлмэг | -Монголын Криминологичдын холбооны удирдах зөвлөлийн гишүүн |
| Г.Золжаргал | -Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны зөвлөх |
| П.Хулан | -Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны референт |

3.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр холбогдох байгууллагаас мэргэжлийн хүмүүсийг оролцуулж ажиллуулахыг Ажлын хэсгийн ахлагч /Ц.Гарамжав/-д зөвшөөрсүгэй.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА Ш.РАДНААСЭД

ХА0316